



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/308

Сүхбаатар су.л

Г

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.2, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 66 зүйлийн 66.3, Төсвийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6, Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Сэлэнгэ энерго", "Цэнгэг ус", "Гавшгай ус" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг, орон тоо, төсөв санхүү, өр төлбөр, авлага, ашиг алдагдлын хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн дарга:

Ж.Сайнцог

-Аймгийн Засаг даргын орлогч

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга:

О.Мөнхбаяр

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Ажлын хэсгийн гишүүд:

Х.Мөнхжаргал

-Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн Ерөнхий нягтлан бодогч

Б.Батмөнх

-Төрийн Аудитын газрын ахлах менежер /зөвшилцсөнөөр/

П.Эрдэнэсайхан

-Аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга

Б.Дарихжав

-Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга

А.Гэрэлмаа

-“Мэдээлэл аудит” ХХК-ны захирал /зөвшилцсөнөөр/

430810771

Л.Баярсүрэн

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Б.Наранзул

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн Бүртгэлийн мэргэжилтэн

3.Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын үйл ажиллагаатай удирдамжийн дагуу танилцан цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан 2021 оны 11 дүгээр сарын 25-ны дотор тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д даалгасугай.

4.Ажлын хэсэгт идэвх санаачилгатай ажилласан ахлагч, гишүүдэд шаардлагатай урамшууллын зардалд 1.800.000 /Нэг сая найман зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-д зөвшөөрсүгэй.

